



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/068/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Хэлтсийн дарга: Б.Лхагвацэнд
Утас: 263533 Цахим хаяг: khagvatsendb@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Мягмаржав
Утас: 263533 Цахим хаяг: myagmarjagt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 07/1023
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Батлан хамгаалах яамны хөрөнгө оруулалтаар цогцолбор төвийн барилгад 100.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, биелэлт 92.9 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-6 Docx

1525070933

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,813,632.20	52,915,793.08
1.1.2	Дансны авлага	162,783,898.14	161,410,650.20
1.1.6	Бараа материал	384,568,807.37	316,242,537.25
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	108,560,439.13	3,136.40
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	100,290,000.00	49,650,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	770,016,776.84	580,222,116.93
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,065,842,499.18	3,105,907,686.53
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,065,842,499.18	3,105,907,686.53
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,835,859,276.02	3,686,129,803.46
2.1.1.1	Дансны өглөг	58,019,309.65	-
2.1.1.3	Татварын өр	19,206,089.27	58,288,438.57
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	12,835,131.88
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	74,420,790.08	126,283,424.92
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	151,646,189.00	197,406,995.37
2.2	Өр төлбөрийн нийт дүн	151,646,189.00	197,406,995.37
2.3.1	Өмч: - төрийн	943,008,420.00	943,008,420.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,079,812,171.30	2,079,812,171.30
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	580,892,169.99	580,892,169.99
2.3.9	Хуримтлагдсан ашиг	80,500,325.73	(114,989,953.20)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(309,040,706.48)	(195,490,278.93)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	389,541,032.21	80,500,325.73
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,684,213,087.02	3,488,722,808.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,835,859,276.02	3,686,129,803.46

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,321,042,620.14	1,542,336,226.84
02	Борлуулалтын өртөг	(904,569,316.94)	(726,699,884.54)
03	Нийт ашиг(алдагдал)	416,473,303.20	815,636,342.30
05	Хүүгийн орлого	903,449.07	203,663.20
08	Бусад орлого	280,345,564.51	57,137,570.90
09	Борлуулалт, маркетингийн зардал	(65,628,246.80)	(143,010,348.99)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(811,168,314.73)	(799,018,080.92)
12	Бусад зардал	(26,727,796.12)	(23,254,248.19)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(7,732.43)	98.21
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(99,840,588.28)	(149,945.68)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(305,650,361.58)	(92,454,949.17)
19	Орлогын татварын зардал	(90,344.90)	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(305,740,706.48)	(92,454,949.17)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	305,740,706.48	(92,454,949.17)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	(3,300,000.00)	(90,308,728.38)
23.3	Бусад олз (гарз)	(3,300,000.00)	(90,308,728.38)
24	Орлогын нийт дүн	309,040,706.48)	(182,763,677.55)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	2,095,895,116.30	580,892,169.99	398,178,589.79	4,017,974,296.08
02	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
04	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(3,300,000.00)	(3,300,000.00)
05	Өмчид гарсан өөрчлөлт	-	(16,082,945.00)	-	-	(16,082,945.00)
06	Зарласан ногдол ашиг	-	-	-	(8,637,557.58)	(8,637,557.58)
07	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(305,740,706.48)	(305,740,706.48)
09	2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	2,079,812,171.30	580,892,169.99	80,500,325.73	3,684,213,087.02
10	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(12,726,601.38)	(12,726,601.38)
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(90,308,728.38)	(90,308,728.38)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(92,454,949.17)	(92,454,949.17)
17	2024 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	2,079,812,171.30	580,892,169.99	(114,989,953.20)	3,488,722,808.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,510,102,327.75	1,778,557,024.48
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,430,433,037.40	1,572,178,661.53
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	46,219.00	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	2,112,575.00	524,189.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	68,377,550.00	90,909,090.91
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,132,946.35	114,945,083.04
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,707,196,263.22	1,739,946,720.83
1.2.1	Ажиллагчдад төлсөн	553,095,369.73	570,644,188.46
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	140,085,714.44	106,350,640.10
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	695,802,701.37	723,729,101.65
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	136,767,629.08	138,761,728.40
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,685,000.00	25,050.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	94,164,960.35	122,563,370.40
1.2.9	Бусад мөнгөн зарлага	85,594,888.25	77,872,641.82
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(197,093,935.47)	38,610,303.65

**Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	194,913.02
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	194,913.02
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	194,913.02
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,530,169.47	300,226.69
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	2,530,169.47	300,226.69
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	11,175,459.48	3,282.48
3.2.4	Төлсөн ногдол ашиг	8,637,557.58	-
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	2,537,901.90	3,282.48
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,645,290.01)	296,944.21
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(205,739,225.48)	39,102,160.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	219,552,857.68	13,813,632.20
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,813,632.20	52,915,793.08

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Өсөлт (+), бууралт (-)	
		Зорилтот түвшин	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	1,409,996,925.19	1,637,000,000.00	1,599,677,460.94	37,322,539.06	97.7
Нийт зардал	1,715,737,631.67	1,553,775,000.00	1,692,132,410.11	(138,357,410.11)	108.9
Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	904,569,316.94	474,474,000.00	438,745,628.42	35,728,371.58	92.5
б) Удирдлагын зардал	811,168,314.73	1,079,301,000.00	1,253,386,781.69	(174,085,781.69)	116.1
Үндсэн болон нэмэгдэл цалин	339,674,815.36	611,599,000.00	681,643,985.75	(70,044,985.75)	111.5
Нийгмийн даатгалын шимтгэл	14,653,638.22	79,625,000.00	14,210,823.00	65,414,177.00	17.8
Түлш шатахууны зардал	25,458,074.10	29,327,000.00	12,303,392.59	17,023,607.41	42.0
Ашиглалтын зардал	63,117,075.29	92,880,000.00	77,011,017.08	15,868,982.92	82.9
Засвар үйлчилгээний зардал	15,456,214.28	21,138,000.00	90,362,753.12	(69,224,753.12)	427.5
Шуудан холбооны зардал	26,072,290.12	27,685,000.00	28,013,641.71	(328,641.71)	101.2
Бичиг хэргийн зардал	3,679,894.99	4,444,000.00	1,822,126.62	2,621,873.38	41.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	147,196,659.74	152,390,000.00	131,620,692.97	20,769,307.03	86.4
Түрээсийн зардал	900,000.00	-	450,000.00	(450,000.00)	-
Мэргэжлийн үйлчилгээний зардал	11,492,600.02	-	16,524,264.64	(16,524,264.64)	-
Томилолтын зардал	9,333,660.00	-	1,204,000.00	(1,204,000.00)	-
Бусад зардал	154,133,392.61	60,213,000.00	198,220,084.21	(138,007,084.21)	329.2
Татвар төлөхийн өмнөх ашиг	(305,740,706.48)	83,225,000.00	(92,454,949.17)	175,679,949.17	(111.1)

**Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

Цэвэр ашиг, алдагдал	(305,740,706.48)	83,225,000.00	(92,454,949.17)	175,679,949.17	(111.1)
Төрийн өмчид төвлөрүүлэх ашиг	-	-	-	-	-
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.22	0.95	1.06	(0.11)	111.4
Нийт ажиллагсдын тоо	55	53	50	3	94.3
Нийт цалингийн сан	673,589,568.00	611,599,000.00	681,643,985.75	(70,044,985.75)	111.5

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 9.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 5.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3.9 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТӨААТҮГ нь ажлын цаг ашиглалт, ажлын гүйцэтгэлд үндэслээгүй, ээлжийн амралт эдэлж буй нэр бүхий 2 ажилтанд 0.7 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл, мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтны орон тоо батлагдаагүй байхад уг орон тоог хавсран гүйцэтгүүлж 20.0 хувийн нэмэгдэл 3.0 сая төгрөгийн, нийт 3.7 сая төгрөгийн цалин илүү олгосон, мөн өөрийн үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй Ховд аймаг явсан 1.5 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан байна.	1	5,259.0	1	5,259.0								
Тайлант хугацааны эцэст 160.8 сая төгрөгийн дансны авлага бүртгэснээс 92.1 хувь буюу 148.2 сая төгрөгийн авлага нь 365-аас дээш хоногийн насжилттай ба найдваргүй авлагын хасагдуулга тооцож, авлагыг цэвэр дүнгээр бүртгээгүй байна. Насжилт өндөр авлагаас "Их барилгын хүч" ХХК-иас 2017 онд үүссэн нүүрсний урьдчилгаа төлбөр болох 3.9 сая төгрөгийн авлагын хариуцагч нь нас барсан тул эргэн төлөгдөх магадлал бага байна.	1	3,862.8					1	3,862.8				
Ресторанаар борлуулж буй барааны үнийг Пос-ын Пацо программ, рестораны меню-ны үнэтэй тулган шалгахад Пос-ын үнэ, меню-ны үнэ зөрүүтэй, Пос-ын үнийг бараа татан авалт бүрд шинэчилж баталдаггүй, бараа борлуулалтын үр дүнд тавих хяналтын процесс тодорхойгүй байна.	1	-					1	-				
ТӨААТҮГ-ын жилийн эцсийн хөрөнгийн тооллогод оролцож, аудитын түүвэрт хамрагдсан үндсэн хөрөнгийг тоолоход коджуулаагүй, зарим хөрөнгийн нэршил тодорхой бус, мөн хөрөнгийн байршил зөрүүтэй байна.	1	-					1	-				
ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгийн бүртгэлд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 109 нэр төрлийн 1,996 ширхэг хөрөнгө байна.	1	-					1	-				

Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

ТӨААҮГ-ын санхүүгийн тайлангийн эздийн өмчийн бусад хэсэг ангилалд 2013 оны 06 дугаар сараас эхлэн үүссэн 580.9 сая төгрөгийг, Батлан хамгаалах сайдын шийдвэрийг тухай бүр гаргуулж, төрийн өмчид бүртгээгүй байна.	1	-					1	-				
Дүн	6	9,121.8	1	5,259.0			5	3,862.8				

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой зөрчлийг давтан гаргахгүй байх 2 албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв ТӨААҮГ-ын эзэмшил газраас Сүхбаатар дүүргийн засаг даргын захирамжаар иргэн, аж ахуйн нэгжид давхардуулан олгосон байна.	1	-	1	-		
Өмнөх аудитаар өгсөн усан бассейныг засварлаж, үр ашиг, орлого нэмэгдүүлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-	1	-		
Дүн	2	-	2		-	-